

СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН

М. Зэнээ

**МАНЖ, ХЯТАДЫН ДАРЛАЛ МӨЛЖЛӨГИЙН ИЛЧИЛСЭН
МОНГОЛ АРДЫН ЗҮЙР ЦЭЦЭН ҮГЭЭС**

Тал сайхан нутагтаа эзэн нь болж Ази тивийн элгэн дээр бие даан оршиж ирсэн удаан жилийн зузаан түүхтэй монголчууд эрт цагаас тусгаар тогтносон, үндэсний өвөрмөц амьдрал, ахуйтай өвөрмөц зан заншил, соёлтой ард түмэн билээ.

Монголчуудын үндэсний соёлын нэг өвөрмөц хэлээр бол ардын аман зохиол юм. Монголын ард түмэн туулж өнгөрөөсөн түүх, амьдрал тэмцлийн сургамж, хойч үедээ үлдээх ёстой соёлын их өвийг ардын аман зохилоор дамжуулан илэрхийлсэн нь цөөнгүй. Бид энд Монгол ардын аман зохиолын арвин их санд харийн дарлалын мөн чанарыг хэрхэн илэрхийлж байсныг зөвхөн Зүйр цэцэн үгээр жишээ болгож байна.

Монгол, хятад хоёр эрт цагаас хаяа даран айл хөрш оршиж түүхийн урт удаан хугацаанд өөр өөрийн улс төр, эдийн засгийн биеэ даасан бодлого явуулахын зэрэгцээ харилцан уулгалах, түр зуур эвлэрэх, худалдаа наймаа хийх зэрэг улс хоорондын харилцааны хатуу зөөлөн олон хэлбэрийг туулж өнгөрөөжээ. Гэвч энэ бүхний цаана хятадын эзэн хаадаас явуулж байсан хэзээ ч өөрчлөгдөж байгаагүй нэг бодлого бол хөрш зэргэлдээ орших Монгол улсыг өөрийн эрхшээлд бүрэн оруулж, хязгаар муж болгох оролдлого байв. Хятадын эзэн хаадаас монголчуудын хувьд явуулж байсан эзлэн түрэмгийлж, хавсарган нэгтгэх бодлогыг монголын ард түмэн бүх түүхийн турш няцааж иржээ. Хятадын эзэн хаад монголчуудыг эрхшээлдээ оруулахын тулд юуны өмнө тэдний нэгдсэн хүчийг сарниах, дотроос нь хагалан бутаргах, өнгө мөнгөөр татахыг чухалчилдаг байв. Уламжлалт ийм бодлогын нэг тодорхой жишээ бол хятадын эртний Хан улсаас Хүннүгийн хаанд гүнж болгон өгч байсан Ван Чжаожүн гэгч хатан юм. М. Э. Ө. 1 зуунд Хүннүгийн хаан Хуханье шаньюйд бэлэг болгон өгсөн энэ хатан монголчуудыг хятадын эрхшээлд оруулах хэрэгт үйлчилжээ. Тийм ч учраас Бээжингийн одоогийн эрх баригчид энэ хатны түүхэнд гүйцэтгэсэн үүргийг магтан сайшаах нь их болов. 1979 онд Хөх хотод «Чжаожүн ба түүний булш» нэртэй номыг хятад хэлээр хэвлэн гаргалаа. Номд «Чжаожүн алс говийн умарт талд оршдог Хүннүгийн нутагт очиж Хуханье шаньюйгийн хатан болсон нь Хан ба Хүннү хоёр үндэстний хоорондын эв нэгдэл, найрамдлын харилцаанд их хувь нэмэр оруулсан»¹ гэж дүгнээд нааш нь «Ван Чжао-жүн нутгаас гарсан нь манай улсын түүхэн дэх олон үндэстний эв нэгдэл, хамтын хөгжлийн нэг сайхан жишээ болсон»² гэж үнэлжээ. Энэ бол монголчууд эртнээс хятадын нэг хэсэг байсан гэж батлахыг оролддог хятадын харгис түүхчдийн хуурамч дүгнэлтийг түүхийн үндэстэй болгох гэсэн оролдлого мөн Монголын ард түмэн хятадын энэ бодлогыг тун сайн ойлгодог байсан учир тэдний бодлогын мөн чанарыг:

¹«Чжаожүн ба түүний булш». Хөх хот 1979. 1-р тал

²Мөн тэнд.

«Эхнэр хүүхдээр бэлэг барьж
Эеэр татах эртний аргатай
Эд мөнгөөр хахуул өгч
Эзлэн захирах эцсийн бодлоготой» гэж зүйр цэцэн үгэнд тусган хэлэлцдэг

байжээ.

«Чжаожүн ба түүний булш» хэмээх энэ номд өгүүлэхдээ «Ван Чжао- жүн Хүннүгийн нутагт очоод зөвхөн хүүхэд гаргаж, эсгий овоохойд сууж, сүү ууж, мах идэж, сэтгэл тогтвортой нүүдэлчдийн амьдралаар амьдарч байсан биш, эцсийн зорилгоо биелүүлэхийн тулд Хуханье шаньюйг үхсэний дараа зохих доромжлолыг хүлцэн тэсвэрлэж «умар зүгийн нүүдэлчдийн ёсыг» дагаж Хуханье шаньюйгийн их хатны том хүүтэй суужээ»³ гэсэн байна.

Вань Чжаожүнийг илгээсэн «эцсийн зорилго» нь монгол угсаатныг хятадын салшгүй хэсэг болгоход түүний алд бие, амь насыг бүрэн золиосолж байсныг дээрх баримтаас ойлгож болно. Хятадын хаад хөрш зэргэлдээ улс үндэстнүүдийг ийм замаар уусгахыг аль эртнээс эрмэлзэж ирснийг түүх аяндаа баталж байна. Гэвч тэдний зорилго биелж байсангүй.

«Эеэр татах хятад бодлого
Өнгөөр дамжин илэрдэг
Эзлэн захирах хэтийн санаа нь

Мөнгөөр уламжлан гүнзгийрдэг» хэмээн монголын ард түмэн хэлэлцэх нь хятадын эл бодлогоос ямар нэг хэмжээгээр хөндий байхыг өнгө мөнгөнд татагдах болзошгүй ноёлогч ангид анхааруулж байсны гэрч бизээ.

Манж нар ч монголыг эрхшээлдээ оруулахын тулд мөн дээрх «хятад аргыг» хэрэглэдэг байв. Үүний эсрэг монголчууд хүчээ нэгтгэн тэмцэхийг туйлаас эрхэмлэж байсан боловч нийтийн тэмцлээс ухрагч нар бас гарч байжээ. Ийм жишээнд монголын тусгаар тогтнолын төлөө тэмцлийн удирдагч Амарсанаа, Чингүнжав нарын үйл хэргээс урвасан Үй жанжин⁴ гэгч орох ёстой. Монголчууд ийм явдлыг

«Тураг шувуу туйлдахдаа
Турлиахайн үүрэнд хонох
Хаад ноёд муудахдаа

Хятадын төрд буух» гэдэг үгээр тун онож зүйрлэн хэлэлцдэг байв.

Монголчууд манжийн түрэмгийлэлд автагдахын зэрэгцээ тэдний гар хөл болж монголд ирж байсан хятадын шунахай худалдаачид, мөнгө хүүлэгчдийн давхар дарлалд туйлын их хэлмэгдэж байлаа. Иймээс монголчууд харь хятадын дарлан мөлжигчдийг эсэргүүцсэн үзэл санаагаа

«Хятад хярд гарч
Хярсын сүүл толгойд гарлаа»
«Хэрмийн сүүл толгойд гарч
Хятадын хөл гэрт гишгэлээ» гэх зэргээр илэрхийлж байв.
«Данжаадын дэнс хатуу
Даалууны нүх хатуу»

«Дотор хүн дотуур тамиртай» гэх зэрэг зүйр цэцэн үг хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчдийн шунахай зан хар санааг уран харуулжээ. Тэд монголын ард түмнийг сорон мөлжих олон арга хэрэглэж байсны дотор өрийг даансыг луйварын аргаар ихэсгэх, хуурамч өр тулгах явдал багагүй байжээ. «Хүн үхэхээс даанс илжрэхгүй» хэмээн

³«Чажоюн ба түүний булш», Хөх хот 1979. 9-р тал

⁴Н. Ишжамц. Монголын ард түмний 1755—1758 оны тусгаар тогтнодын зэвсэгт тэмцэл. УБ. 1962. номноос үзнэ үү.

хэд хэдэн үеийн өмнөх өр нэрээр хоосон өр нэхэж ард олныг шулан дээрэмдэх аргыг хятад мөнгө хүүлэгчид хэрэглэж байв. Хятад худалдаачид, мөнгө хүүлэгчдийн ийм аргыг тусгасан

«Данжаад бараа зээлдүүлж
Дансныхаа хүүг нэмж бодно
Даалуучин нүх нийлүүлж
Дахин авах хожлоо бодно»

«Хуурамч ураг дурсаж
Хуурайлж авахыг боддог
Танил тал дурсаж

Талж авахыг боддог» гэх зэрэг олон зүйр үг монголчуудын дунд өргөн дэлгэрчээ.

Хятадын мөнгө хүүлэгч худалдаачдын уршгаар монголын ядуу ард түмэн хэлмэгдэн хоосрох нь ердийн үзэгдэл болов. Баруун монголд зарим хятад пүүс нэг цайг жилийн хугацаанд зээлдүүлэхдээ өвлийн улиралд ямааны 3 арьсаар тооцоолж байв. Хэрэв өвөлжингөө уг өр төлөгдөхгүй бол зун нь ямааны гурван арьсыг 3 амьд хурга болгон төлөх ёстой байв.⁵ Энэ гурван хурга дараа жил гурван төлөг болох ба хэрэв охин хурга бол 6 хониор бодож өр нэхэгдэх жишээтэй байжээ.

Хятадын томоохон пүүсүүд монголын аймаг хошуудыг эдийн засгийн хувьд бүрэн эрхшээлдээ оруулахын тулд олон тооны хүмүүсийг гар хөл болгон ажиллуулж байлаа. Жишээ нь: Зөвхөн ганц Даашинхүүгийн пүүс гэхэд л 100 шахам бичээч нарыг зарж байв. Тэд нар түнш аймаг хошуудаас өр нэхэх, барьцаанд мал, түүхий эд хураан авах зэрэг ажил эрхэлж байв»⁶ Тийм пүүсний төлөөний хүмүүсийг «Доншуур маймаа», «Ганзгын маймаа» гэж ярилцдаг байв. Энэ тухай ардын зүйр үгэнд:

«Дорго хэмээгч амьтан
Малын бөгс ухагдаа сурмаг
Доншуур хэмээх маймаа
Хүний юм салгахдаа чадмаг» гэсэн байдаг.

«Доншуур маймаа» нар монгол газраар ийнхүү хэрэн хэсч явахдаа өөрсдийн хувийн эрх ашгийг ямагт давхар бодолцох тул монголчууд хэдэн давхар мөлжүүлэхэд хүрч хожим нь тэд баян чинээлэг болж хувирсан нь цөөнгүй байв.

«Хуучин цагийн доншуур маймаа

Хожмын өдрийн баян данжаад» гэсэн зүйр үг дээр өгүүлснийг бүрэн тусгасан санааг агуулжээ.

Монгол дахь хятад пүүсний ийм жижиглэн худалдаалах үүргийн маймааны арга хамгийн их дэлгэрсэн бөгөөд орлого ихтэй хэлбэр байв.

Монгол газар хятад худалдаачид, мөнгө хүүлэгчид, цэргийн харгис эрхтнүүд олширсон нь монголчуудын хувьд хүнд дарамт болж байв. Тэд монголын ард түмний аж амьдралыг улам доройтуулж малын бэлчээр нутгийг хагалан тариалж, ашиг хонжоо эрэх, байгалийн баялгийг хулгайн аргаар тонон дээрэмдэх, тэрчлэн монголчуудтай ураг барилда- хыг эрхэмлэх зэргээр амьдралын бүх хүрээнд улам улам нэвтрэн орж, эрх дархаа бататгахыг эрмэлзэж байв. Ийм бодлогыг эсэргүүцсэн ардын зүйр цэцэн үг монголын ард түмний ихэд дэлгэрчээ.

«Данжаад ихэдвэл дажин
Давалгаа ихэдвэл шуурга»

«Хялар ихэдвэл сохор

Хятад ихэдвэл дажин» гэх зэргээр хятад хаана олон бол

⁵БНМАУ-ын түүх. II боть УБ., 1968. 290-р тал

⁶Ш. Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа. (1850—1919) УБ. 1971. 55-р тал

тэнд элдэв самуун будлиан гарч, ард түмний эрх ашигт харшилж байсныг үзүүлжээ.

«Монгол дахь хятадууд яавал үнэн, худал аргаар хөрөнгө хогшил цуглуулж дараа нь нутаг буцаад санаа амар амьдарч насыг барах вэ гэсэн ганц бодол өвөрлөж байв...»⁷ Үүнээс үүдэн манай ард түмний дунд хятад цагаачдын талаар тэднийг

«Ирэхдээ зүүний сүвэгчээр багтавч

Буцахдаа да-мин хаалгаар багтахгүй» гэдэг зүйр цэцэн үг гарчээ.

Манай ард түмэн манж, хятадын төрөөс монголчуудын хувьд явуулж байсан бодлогыг олон хэлбэрээр эсэргүүцэж байсны нэг жишээ бол монголд ихээхэн дэлгэрсэн «сайн эрчүүд»-ийн тэмцэл юм. Ард түмэн гадаад дотоодын дарлалд яс чөмгөө хүртэл соруулж, амьдралын туйлын хүнд байдалд орсоны жинхэнэ шалтгаан нь хятадын мөнгө хүүлэгчид, худалдаачид болоод манжийн дарангуйлагчдын гай уршиг хэмээн үзэж худалдаачдыг уулгалан дайрч, пүүс дэлгүүрийг дээрэмдэн, өрийн данс, бичгийг түймэрдэх зэргээр хорсол бухимдлаа тайлдаг⁸ явдал цөөнгүй гарч байв.

Тэд гадаадын дарлагчдаас булаан авсан зүйлээ жирийн ядуу олонд тараан өгч, тэднийг амьдралын хувьд түр ч атугай тэтгэдэг байсан учраас ядуу ард түмний дунд туйлын их нэр хүндтэй байжээ. Манж амбан, хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчдийн ихээхэн айдаг юм нь «сайн эрс» байсан учраас олон түмний дунд:

«Малын дайсан саарал чоно

Маймааны дайсан сайн эр» хэмээх зүйр үг хэлцэгдэх болжээ.

Манжийн дарангуйлагчид, тэдний гар хөл болж байсан хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчид монголчуудыг эдийн засаг, улс төрийн хувьд дарлаад зогссонгүй, монголын малын үржил шимтэй бэлчээрийг хагалан тариалж, байгалийн баялгийг тонож зөөх нь их байв. Хятадууд газар хагалбарлан тариа тарих явдлыг шийдвэртэй эсэргүүцэж:

«Хятад хүн

Хүн, хүний ёс хоёрыг залгина.

Хятад тариа

Мал, малын бэлчээр хоёрыг залгина» хэмээн хэлэлцэх болжээ. Энэ зүйр үг утга санааны хувьд хятадын хөдөлмөрч ард түмнийг биш, харин тэднийг турхиран хөөж буй мөлжигч ангийн төлөөлөгчдийн тухайн бодит байдлыг гүнзгий тусгажээ. Хятад худалдаачид, мөнгө хүүлэгчид хувийн эрх завшааны төлөө юу ч хийхээс буцахгүйд хүрч ард түмний үнэнч шударга хэв заншлыг эвдэж байсан нь монголчуудаас тэдэнд хандах хандлагыг туйлын хүйтэн болгосон хэрэг. Үүнээс болж монголчууд «хятад хүн-хүн, хүний ёс хоёрыг залгина» гэж хэлэлцэх болсон нь харийн дарлалын эсрэг монголчуудын үзэл санааны өсөлт идэвхижиж байсны гэрч билээ. Хятадын дарлагчид монголын ард түмнийг дарлаж мөлжиж байсны тодорхой жишээ бол тэдний амьдралын гол нөхцөл болсон малын бэлчээрийг хагалж тариа тарьж, мал аж ахуйг шахаж байсан нь нэг ёсондоо «мал, бэлчээр хоёрыг залгиж» байсан хэрэг ажээ. Газар хагалж тариа тарих хятад олширсонд дургүйцсэн монголчууд

«Гахай хятад хоёр олширвол

Газрын хөрс үлдэхгүй» хэмээн малын бэлчээрийн төлөө шийдвэртэй тэмцэл явуулж байсан жишээ цөөнгүй.

⁷И. Майский Современная Монголия. Иркутск. 1921. 71-р тал

⁸БНМАУ-ын түүх II боть УБ. 1968. 249-р тал

Хятадын төрөөс монгол улсын хувьд явуулж байсан эзлэн түрэмгийлж, хавсарган нийлүүлэх бодлого олон үеийн хятад хаадын эрмэлзэж ирсэн зүйл учраас монголын ард түмэн:

«Тив дэлхийд харанхуй дайсан

Төр улсад хятад дайсан»

«Төрийн дайсан хятад

Төмрийн дайсан хуурай» гэх зэргээр хэлэлцэн хятадын ард түмнийг биш, харин хятадын хаад ноёдын төрийн бодлогыг эсэргүүцэж иржээ. Манж, хятадын түрэмгийлэлийн үед тэдний гар хөл болж монгол орноо ирж байсан хятад худалдаачид мөнгө хүүлэгчид, цэргийн харгис эрхтнүүд монголын үндэсний эрх ашиг, төрийн тусгаар байдалд байнга заналхийлж байсан учраас тэднийг эсэргүүцсэн санаа бодлоо ард түмэн:

«Хятад хүн эхэндээ

Хэлэн дээр чихэр түрхээд

Эцэстээ

Шилэн дээр хутга тавина» гэх зэргээр илэрхийлж, залгамж үедээ захиас болгон үлдээж байсан нь цөөнгүй. Энэ нь мөн л хятадын эрх барих бүлгийн бодлогыг илчилсэн цэцэн үг юм.

Тэд монголчуудыг эрх чөлөөгүй дарлан боолчилж, эрхшээлдээ бүрэн барьж байх зорилгоор цэрэг зэвсгийн хүчийг нэг биш удаа хэрэглэж байсан төдийгүй монголын газар шороонд шунаж, цаг үргэлж хомхойрон байсныг манай ард түмэн ардын аман зохиолдоо тусган

«Хар хятад сэтгэл муу

Ханиа ч хазна, ижлээ ч хазна

Хамтрах болбол сэрэмж хэрэгтэй

Хаяагаа хадрахаас ч буцахгүй»

«Харамч хүн ханьдаа халтай

Хадраач гахай дулзгандаа халтай

Хав муур оготононд халтай

Хар хятад хөршдөө халтай» гэж хэлэлцэж байсан нь тухайн үеийн бодит үнэнийг тусгаад зогссонгүй энэ зүйр үг өнөөдөр ч үнэ цэнээ алдаагүй байна.

Монголын ард түмэн манж, хятадаас монголын хувьд явуулж байсан бодлогын мөн чанарыг ардын зүйр цэцэн үгэнд гүн гүнзгий тусган хойч үедээ үлдээсэн нь туйлын их бөгөөд бид түүнээс зөвхөн хэдийг жишээ болгон өгүүлэхэд ийм байна.

МОНГОЛЬСКИЕ НАРОДНЫЕ ПОСЛОВИЦЫ, ОТРАЗИВШИЕ ГНЕТ И ЭКСПЛУАТАЦИЮ НАРОДА КИТАЙСКИМИ И МАНЬЧЖУРСКИМИ КОЛОНИЗАТОРАМИ

Резюме

История, быт, социально-экономическое положение любого народа находят свое проявление в народном творчестве. Монгольский народ, на протяжении двух столетий испытывавший на себе эксплуатацию и гнет маньчжурских завоевателей и китайских ростовщиков, сохранил в своей памяти большое количество преданий, песен и легенд, связанных с этим

мрачным периодом истории Монголии. Фольклор являлся одной из форм выражения недовольства притеснителями. Это хорошо чувствуется в пословицах-самом кратком по форме и объемном по содержанию образце классического устного народного творчества.

Монгольские пословицы того периода, выражали настроение широких масс монгольского народа, его отношение к событиям внутри страны, к отдельным, характерным случаям во взаимоотношениях с маньчжурской администрацией и китайскими ростовщиками.

В статье приводятся примеры монгольских пословиц, обличающих сущность китайского ростовщичества, продажность верхушки монгольской феодальной знати. жадность и тщеславие китайских ростовщиков.

В отдельном ряду стоят пословицы и поговорки, посвященные отдельным выходцам из народа (сайн эр), в одиночку или небольшими группами боровшихся против бесчинств маньчжуров и китайцев.

Некоторые пословицы и поговорки не потеряли свою актуальность и в настоящее время. О них вспоминают в Автономных районах КНР прежде всего во Внутренней Монголии, население которых непосредственно на себе ощущает горький вкус шовинистической политики пекинского руководства.